



АНХААРУУЛГА ЗӨВЛӨМЖ

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.22, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 202 тоот тогтоолоор батлагдсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-д заасан чиг үүргийн хүрээнд радио, телевизээр нэвтрүүлж буй сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийж байна.

Сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт буюу сурталчилгааны сүүлийн 2 өдөрт дараах заалтыг зөрчихгүй байхад онцгой анхаарч, редакцидаа хатуу хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Сонгуулийн сурталчилгааг хоногт хоногт 60 минутаас хэтрүүлэхгүй байх (Хуулийн 45.6);
2. Нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдох хоногт гарах 15 минутыг хэтрүүлэхгүй байх (Хуулийн 45.7);
3. Нэр дэвшигч **оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад** хэлбэрийн **бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага** нэвтрүүлэхгүй (Хуулийн 47.10) байхад тус тус анхаарч ажиллана уу.

Сонгуулийн сурталчилгааны сүүлийн 2 хоногт буюу **10-р сарын 08, 09-ний** өдрүүдэд **дээрх заалтуудыг зөрчсөн тохиолдолд** Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.26-д заасны дагуу тухайн радио, телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг **Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүчингүй болгох арга хэмжээ авах хуулийн зохицуулалттай** байгааг анхаарна уу.

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

2024.10.08